

МОНГОЛ “ЖАНГАР”-ЫН БҮЛГҮҮД ДЭХ ЖАНГАР БААТРЫН ТОДОТГОЛ НЭРШИЛТ ЦОГЦОЛБОРЫН ХЭЛЗҮЙН ХАРЬЦУУЛСАН СУДЛАЛ

О.Отгонбаатар, магистр, МУБИС

Abstract

Jangar epic is the infinite found of Mongolian language, culture and mindset with numerous vocabulary, description of poem and poetry. Thus, I proposed the epic to highlight the Jangar poem's feature such as language, expression comparison and movement, word choice and origin as researching Jangar epic by linguistic, stylistic method. The “Jangar” study has been extending its frame incredibly for the several recent years and entered into a total new era of fresh research based on folk theory and methodology study. Researchers have learned the Jangar study in multiple branches for instance history ethnography, cultural mind, international comparison study of the original text, structure and form, establishment, motive, form and description, narrative, play and acting, social code and verbal form etc.

The understandable reveal and expression of social life is generalized by historic science. Yet, the ethnography study involves its implying roots. Therefore the language is the science which shows the deep sense and meaning of mindset regardless of time limit at the level of both fool and wise. In other words the comparison linguistics analysis the fixed actions and approves grammar and stylistic modification.

Түлхүүр үг

Монгол баатарлаг туулийн туурвил зүйн харьцуулсан судлал, соёл сэтгэлгээний үнэт зүйлс

Удиртгал

“Жангар” судлал нь орчин үед судлалын хүрээгээ асар хурдацтай тэлж, аман зохиолын олон онол арга зүйн судлалд суурилсан цоо шинэ судлалын нэгэн эрин үедээ ирээд байна. Судлаачид Жангарын туулийг түүх угсаатан, соёл сэтгэлгээ, эх текстийн олон улсын харьцуулсан судлал, бүтэц хэв шинж, байгууламж, мотив, дүр дүрслэхүүн, хүүрнэл зүй, тоглолт жүжиглэлт, зан үйл, аман хэв хэвшил гэх мэтээр “Жангар” судлалын олон салаа мөчрийг хэдийнээ бий болгожээ. Тэгвэл “нийгмийн амьдралын ухамсартай илрэл үзэгдлүүдэд хамарч буй өгөгдлүүдийг түүхийн ухаан нэгтгэж ерөнхийлдөг. Харин угсаатан судлал түүний далд ухамсарлаг үндсүүдэд хамаарахыг нь авч үздэг (Отгонбаяр, 2013, х.25). Тэгвэл хэл бол ухамсарт болон ухамсаргүй хэлэхүйн түвшинд ертөнцийн өгөгдлүүдийг танин мэдэхүйн тэмдэгт болгон хувиргадаг тул цаг хугацааны хязгаарлалтыг даван туулж, сэтгэлгээний үндсэн гүн утга чанарыг таниулдаг шинжлэх ухаан болно. Тиймээс харьцуулсан хэл шинжлэл нь тогтсон үзэгдлүүдийг задлан шинжлэх замаар, мөн тэдгээрийн сэлгэлт, хувиргалт, байрлалыг судлах байдлаар хэл зүй, өгүүлбэр зүйн өөрчлөлтийн нотолгоонуудыг олж, ойлгон ухамсарлаж тэдгээрт дүн шинжилгээний дүгнэлт тодорхойллыг өгч болно. “Хэл шинжээчдийн үлгэр жишээг дагаж мөрдсөөр социологийн үлэмж их амжилтад хүрэх нь дамжиггүй... хэмээн Марсел Мосс бичжээ (М. Mauss, 1950, х.73)” Гэтэл бид үнэн хэрэгтээ ийм маягийн герменевтикийн шинжлэх

ухааны төвшний судалгаанд хүрч ажиллаж чадахгүй байгаа ч гэсэн аман зохиол, угсаатны аман зохиолын интеграц төвшний судалгааг хэл шинжлэлийн судлалаар дамнан судлах нь ядахдаа өөрийн төрөлх монгол хэлтний хэл, соёл сэтгэлгээний мөн чанарыг ухаарахад нэг алхмаар урагшилна. Тэгэхийн тулд орчин үеийн хэл шинжлэлийн аргад суурилсан судалгаагаар эрт үеийн эх текстүүдийг харьцуулан судлах нь эдүгээ үед аман зохиол судлагч нарын өмнө тулгараад буй шинэхэн судлалын онол арга зүйн чиглэл юм.

Энэхүү шалтгааны улмаас тус өгүүллээ нийт монгол хэлтний “Жангар”-ын тууль дахь баатрын нэрсийн цогцолбор (М. Базаррагчаа, 1989, х.12) (Цогцолбор гэдгийг: “Монгол хэлний эхийн тухай” номдоо: “Хэмжээс их нэгжийг эх гэж болно. Эхийн үндсэн нэгж нь цогцолбор дискурс юм. Уул эхийг бүтээх, бусад эхээс ялгах, тухайн нэг санааг агуулсан хэд хэдэн өгүүлбэр нийлснийг хэлний талаас цогцолбор, хэлэхийн талаас цогц гэнэ. Үүнийг оросоор “Сложное синтаксическое целое, сверхфразовое единство” гэжээ) өгүүлбэрүүдийг дагнан өөр хооронд нь харьцуулан судлах нь цаашдын “Жангар”-ын туулийн бүхийл эх текстийн хэл зүйг судлах эхлэл болно гэж үзэж байна. Бид энэхүү судалгаандаа Т.Баясгалангийн 2011 онд хэвлүүлсэн “Жангар” хэмээх номд “Жангар”-ын 33 эх текстийг баримтын тулгуураа болгов. Учир нь Жангар судлаач доктор Т.Баясгалан нь үе үеийн “Жангар” судлаач нарын монгол улсын нутаг дэвсгэрээс тэмдэглэн авсан “Жангар”-ын эх

текстүүдийг болон “Жангар” судлалаар голчлох эрдэмтэн болох У.Загдсүрэнгийн “Жангарын туульс” /1968/, “Аянан Алдарт Аялган Хонгор” Аман зохиол судлал боть:11, /1978/ гэх бүтээлд хэвлэгдсэн “Жангар”-ын эх текстийг шууд тус номдоо хуулбарлан оруулалгүй зарим нэг монгол Жангарт холбогдолгүй эхийг хассан ба тус номдоо хавсаргасан эх текстийг хэл зохиолын хүрээлэнгийн хөмрөгт буй уг бичмэл текст болон авианы текстэй нь харьцуулан тулгаж уг эхтэй нь ойртуулан засан сайжруулсан. Мөн шинээр тэмдэглэсэн “Жангар” туулийн Хавхан Хар Соёогийн бүлгийн 4 хувилбар, Долдой зээрд хэмээх дууг нэмэн оруулжээ. Энэ бүтээл бол эдүгээ үед Монгол улсын нутаг дэвсгэрээс сурвалжлан тэмдэглэсэн “Жангар”-ын бүлгүүдийг үндсэнд нь хамарч чадсан “Жангар”-ын эрдэм шинжилгээний эх материал гэж үзэж байна. Тус номд “Жангар”-ын бүлгүүдэд дүрслэгддэг Жангар баатрын дүр нь бүх бүлэгт ахин дахин давтагдах дүрийн тогтонги, тодотгол нэршлүүд болно. Энэхүү Жангар баатрын дүрийн тодотгол нэршил нь өөр хоорондоо ялгаатай тул монгол Жангарын бүлгүүдийг хувилбарт эхийн хүрээнд хамруулан “Жангар”-ын Жангар баатрын тодотгол нэршилт цогцолбор дахь энгийн өгүүлбэрийн хувиргал>>, <<“Жангар”-ын Жангар баатрын тодотгол нэршилт цогцолбор дахь нийлмэл өгүүлбэрийн хувиргал>>, <<“Жангар”-ын Жангар баатрын тодотгол нэршилт цогцолбор дахь авиа зүйн хувиргал>> гэх монгол хэлний өгүүлбэр зүйн задлалын гурван үндсэн хэсгээр задлан шинжлэх нь “Жангар”-ын туулийн баатрын тодотгол нэршилт цогцолбор өгүүлбэрийн бүтэц бүрэлдүүлбэрийн туурвил зүйг ойлгон ухаарахад ач тусаа өгнө гэж найдаж байна.

“Жангар”-ын Жангар баатрын тодотгол нэршилт цогцолбор дахь энгийн өгүүлбэрийн хувиргал

Монгол хэл судлаач эрдэмтэн профессор Б.Пүрэв-Очир “өгүүлбэр судлал”-ын талаар туулийн оновчтой, дэлгэрэнгүй тодорхойлсныг энд дурдвал: Өгүүлбэр судлалд бодит байдлыг нэрлэж тэмдэглэсэн өгүүлбэрийн гүн бүтэц нь мэдэгдэхүүндээ, түүний загварчлагдсан бүтэц болох цөм бүтэц нь хэлэндээ, харин тухайн цөм өгүүлбэрийн хувилбарт бүтэц буюу үүсмэл өгүүлбэрүүд нь хэлэхүйдээ, өгүүлэгч, сонсогчийн хэлний боловсрол, хүсэл зорилго, туршлага, бэлэг тэмдгийн ёсон, хэлний соёлоос шалтгаалах утга санаа, мэдээллийн бүтэц, хэрэглээний тал буюу өнгөн бүтэц нь мэдэхүүндээ байдаг гэж үзэх бүрэн үндэстэй аж. Эндээс харахад, тогтвортой хам бүтэц болох “эх өгүүлбэр”, “цөм өгүүлбэр”-ийг хэлэнд хамруулж, тогтворгүй цуваа бүтэц болох “үүсмэл өгүүлбэрүүд”-ийг хэлэхүйд

хамруулж, хэлнүүдийн хэв шинжийн түгээмэл ба ялгаатай шинжийн үүднээс, гүн ба өнгөн бүтцийн харьцаанд нь тулгуурлаж, “өгүүлбэрт хувиргал хийх арга”-ыг судлах нь онол-аргазүйн гол чиг хандлага юм (Б. Пүрэв-Очир, 2006, х.5). гэснээс үзэхэд ерөөс монгол хэлний эх текстүүд нь аман ба бичгийн хэлний тогтолцоонд суурилах ба аман ярианы загварчлал нь тогтонги шинжийг үл илэрхийлж, үүсмэл өгүүлбэрт багтах, мөн тэдгээр үүсмэл хэв шинжийг ижил ба ижил бус нэгэн цогцолбор өгүүлбэрүүдийг хэлбэрийн болон агуулгын хувиргалтын төвшинд судлах нь зүйтэй. Мөн эдгээр хэлэхүйн хэлбэр нь өгүүлэгч, сонсогчийн хэлний боловсрол болон үгсийн сангийн нөөц баялагт тулгуурладаг байна. Энэхүү монгол хэлний өгүүлбэрт хувиргал хийх арга зүйг монгол хэлтний баатарлаг “Жангар” туулийн текстээс бүрнээ ажиглаж болно. Тухайлбал баатарлаг туульсын гол баатруудын нэршил нь олон хувилбарт эх текстүүдэд үргэлж тогтонги биш хувирсан байдлаар дүрслэгддэг. Энэ нь тухайн хайлагчийн уран сэтгэмж, хэлний боловсрол, үгсийн сангийн нөөц бололцоо, тухайн цаг мөч, сонсогчийн харьцаа гэх мэт олон зүйлсээс шалтгаалж болно. Жишээ нь Дорнод аймгийн Матад сумын Эрэгзэнгийн Лувсанжамцаас 1948 онд Намсрайн Шарав-Иш тэмдэглэн авсан “Жангар богдын үлгэр” гэх жангарын эх текст дэх Жангарыг Дорнод аймгийн Матад сумын халх ястан, хатиган ургийн овогтой Наянтайн Дүгэрээс 1966 онд Ч.Намсрайжав соронзон хальсанд бичиж авсныг У.Загдсүрэнгийн эмхэтгэсэн “Жангарын туульс” 1968 номд орсныг Т.Баясгалан уг соронзон хальсны текстэй харьцуулан тулгаж ахин хэвлэсэн “Богд ноён Жангарай хаан” гэх бүлэг дэх Жангар баатрын нэршлийн цогцолбор өгүүлбэрийг харьцуулан үзье. Хойш олон хувилбарт текстийн өгүүлбэрүүдийг харьцуулах учир текстийн дугаар болон хайлагчийн нэр, хайлагч нь тодорхойгүйг нь тэмдэглэгчийн нэрээр дөхөмчлөв.

1.[Лувсанжамц]

Эрт урьд нэгэн сайн цагт
Цагаан ууланд нутагтай
Цоо шинэ намаржаатай
Бошог их хаваржаатай
Жин далай, жинт далай,
Бум далай, бусад далай
Энэ дөрвөн далайн
Тэг дунд суудаг
Догт Жамбал Зулын ач жич
Тахил Богд хааны хүү
Үхэн үхтлээ үзэлцэн үл ханагч,
Үгүйрэн үгүйртлээ цавчилдавч
Үл ханагч,
Үйзэн алдар хааны хүү

Үрийн багахан
 Богд ноён Жангар хаан гэгч байжээ...
 1: (Т.Баясгалан, 2011, х.19)

2.[Дүгэр] Эртээ урьд цагт
 [Гэнэн цагаан ууланд] өвөлжөөтэй,
 Бошгийн эхэн хаваржаатай,
 Чин далай, чихэр далай
 Бум далай, бурман далай
 Энэ дөрвөн далайн
 Тэг дунд нутаглан суудаг
 Цогтгор Замбал зулын
 Ачит жичит,
 Тахил Будал хааны хүү
 Үхэн үхтлээ
 Үл цочирдон унагч
 Үйзэн-Алдарай хааны хүү
 Үрийн баахан
 Богд ноён Жангарай хаан гэж байжээ...
 2:(Т. Баясгалан, 2011, х.9) гэсэн Жангарын тодотгол нэршилт цогцолборыг ажиглан үзвэл: “Цагаан ууланд нутагтай, Цоо шинэ намаржаатай” гэж Жангарын орон байр байцыг заасан мөр нь хамтрахын тийн ялгалын “*тай*” дагавраар “нутагтай, намаржаатай” гэх ойролцоо утгат тодотгол өгүүлбэрээр баруун гар тийш нь нэмэн дэлгэрүүлж, зэрэгцүүлэн залган ахиулан давтаж “*Жин далай, жинт далай*”, “*Бум далай, бусад далай*” хэмээх ойролцоо утгат хоршсон зэргэдийг бүтээжээ. Тус өгүүлбэрт буй “*жин, жинт*” гэсэн хэлбэр хэмжээ, дүр төрх заадаг тэмдэг нэрийн язгуурыг эс өөрчлөн давтаж, тухайн тэмдэг нэрийн утгыг улам эрчимжүүлэн “*далай, далай*”-гаар сөөлжлөн холбож “*энэ дөрвөн далайн тэг дунд суудаг*” хэмээн харьяалан хамаатуулах утгаар холбосон байна. Харин “*Догт Жамбал Зулын ач жич, Тахил Богд хааны хүү*” хэмээх нэрийн бүлгийг тоочин “*үхэн үхтлээ үзэлцэн үл ханагч, үгүйрэн үгүйртлээ цавчилдавч*” гэж баатрын зориг санааг “*үхэн - үхтлээ*”, “*Үгүйрэн үгүйртлээ*” гэх улам эрчимжүүлэн хүч түрсэн тэмдэг ба нэр үгийн холбоо үгс болон дутагдан холбох “*вч*” нөхцөлөөр “*үл ханагч*” хэмээх утгыг тодруулсан шинжтэй. Одоо хоёрдугаар 2.[Дүгэр] текстийг дөхөмчлөн задлан үзэхэд “*эртээ*” хэмээх ярианы найруулгаар эхэлж “*гэнэн цагаан ууланд өвөлжөөтэй*” хэмээн хамтрахын тийн ялгалаар зэргэд өгүүлбэр бүтээж “*чин далай чихэр далай бум далай, бурман далай*” хоршоо үгийн аялгаар “*эхэн дөрвөн далайн тэг дунд нутаглан суудаг*” хэмээх мөрүүдтэй холбогдсон байна. Удаах мөрөнд нэрийн бүлгийг дурдаж үхэн үхтлээ “*тэл*” хэмээх угтан холбох нөхцөлөөр “*үл цочирдон унагч*” гэж тодотгон өгөөд Жангарын удам угсааны учир шалтгаант дарааллыг нөхцөлдүүлэн ахиулахдаа нэрийн бүлэг болох “*Үйзэн алдар хааны хүү Үрийн баахан Богд ноён Жангарай хаан*” гэж байжээ гэж өхөөрдлийн

“*ай*”-гаар буюу ярианы хэлэхүйгээр төгсгөсөн шинжтэй юм. Ийнхүү хоёр текст дэх “Жангар” баатрын тодотгол нэршил хувиргалтыг ажиглан үзэхэд зарим өвөрмөц хэлэхүйн харьцаанд хамаарах зүйл байна. Тухайлбал “*Догт Жамбал Зулын ач жич*”, “*Цогтгор Замбал зулын*”, гэсэн Жангарын удам угсаа гарвалийг шүлэглэсэн мөрөнд “ц,з”, “ж,з” гийгүүлэгчийн авиа сэлгэцийн хувиргалт явагдсанаар үл барам “Цогтгор”, “Догд” гэсэн тодотгол үгсийн үгийн язгуур нь “Цог”, “Дог” гэж үзвэл үгийн эхэн дэх авиаг сэлгэснээр цог жавхааны “цог” нь “дог” болж хувирсан мөн 7.[Гончигжанцан] хувилбарт дан ганц үгийн язгуур болох “Даг Жамбал Зулын ач” ч гэж тэмдэглэсэн байна. Харин энэхүү язгуур “Цог” гэх үг нь монгол хэлэнд: цог заль, цогтой зальтай, гал цогтой гэсэн утгыг илэрхийлэх бөгөөд “Цогтгор” гэсэн үг нь олонх тохиолдолд цовоо жавхаатай гэсэн өхөөрдлийн янзтай хэлэхүйд хэрэглэдэг үг нь “Догт” болтлоо хувирсан байна. Энэ бол чухамдаа “хэлний үе үеийн хувьсал, түүхэн онцлогоос болж “үг чулуужин” өөрчлөгддөг, эсвэл, аливаа “хөөрхий үг” эх хэлнээсээ гараад, хэдэн мянган бээрийн замыг туулан явж, зээлдэгдэн нутагшин, бүтэц дуудлагын талаасаа танигдахын аргагүй болтлоо өөрчлөгдөхүй дор амийг нь тээж явдаг ганц зүйл бол тухайн үгийн язгуур нь байдаг нь сонин юм” (Б. Пүрэв-Очир, 2009, х.101) гэх хэл шинжээчдийн судалгааны ажиглалт тодорхойллыг нотолж байна. Харин одоо бид Жангарын дүрслэлд цөм өгүүлбэрийг хэрхэн дэлгэрүүлснийг ажиглан үзье. 12.[Санжаа] хувилбарт бүлэгт Жангарыг хамгийн товч байдлаар “Үеийн үед Жангарай хаан гэж байжээ” (Т.Баясгалан, 2011, х.102) гэж ганцхан мөрөөр хамгийн товч утгаар дүрсэлсэн бол 23.[Найдан] дугаар туульч 28 мөр шүлэг болтол нь дэлгэрүүлснийг энд сийрүүлбэл: 23.[Найдан]-гийн хувилбарт. Задлалыг тодорхой болгохын үүднээс мөр шүлгүүдийг дугаарлав.

1. Эрт урьд нэгэн цагт
Найтаг найлзуур байхын цагт,
2. Дайныг дарж чадсан,
Гарьд шувуу нь
Дархан цолыг олон чадсан,
Дэгдмэл өндөг байхын цагт,
3. Сайн галавын мянган бурхан
Тэргүүлсэн сайн цагт,
4. Сүүн гурван далайг
Балчиг шалбааг байхын цагт,
Сүмбэр гурван уулыг
Гүвээ дов байхын цагт,
5. Захын мод нь
Загал байхын цагт,
Загал бугыг янзагыг
Тугал байхын цагт,
6. Сайн галавын мянган бурхан

- Тэргүүлсэн сайн цагт,
7. Дайныг дарж чадсан,
Дархан цолыг олж чадсан,
Бусдыг олон чадсан,
Бурхан цолыг олон чадсан,
8. Бамбай Ядам Чойсүрэн нутагтай,
9. Тавхай тавхайнаас нь
10. Тансан Гомбо Найчин Лүйзэн

Хааны хөвүүн алд (Үе удам гэсэн утгатай)

Галивар зандан мод нь Богд ноён Жангар хаан гэж л... (Т. Баясгалан, 2011, х.82) гэсэн цагийн байц гишүүнт хэвшсэн хэлц, байдал заасан үйлийн бүлгийн тогтвортой хэлцээр зэрэгцүүлэн тодотгон дэлгэрүүлсэн цөм өгүүлбэрийн дэлгэрүүлэх аргыг нарийвчлан задалж үзье. Тус цөм өгүүлбэрийн 2 ба 7 дахь дүрслэлийн ерөнхий утга нь монгол баатарлаг туульд олонтоо тохиолдох “Бугаан дарж бурхан цолыг олох, дайснаа дарж дархан цолоо олох” гэсэн утгыг дүрслэл 1-д хураангуй хэлбэрээр харин 7 дугаар дүрслэлд дэлгэрэнгүй хэлбэрээр буюу ойролцоо утгат холбоо үгийн хэлбэрээр давтан дэлгэрүүлсэн байна. Харин 3 болон 6 дугаар дүрслэл бол мөн л баруун Монголын баатарлаг туульд ихээхэн тохиолдох хэвшсэн өгүүлбэр нь цагийн утгат нэрээр удаах “*чадсан*” гэх хэл зүйн үйлийн холбоо үг давтсан мөрүүдтэйгээ холбосон шинжтэй юм. Мөн 5 дахь дүрслэл бол туулийн оршил хэсгийн цаг үеийн магтаалд олонтоо тохиолдох цагийн байц гишүүнт зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийг “*цагт*” гэх үйлийн холбоо үгийн давталтаар ба ойролцоо утгат тодотгогч гишүүн өгүүлбэрүүдийг холбож өгсөн байна. Дөрөвдүгээр дүрслэл бол мөн л аман зохиолд цагийн утга заасан хэвшсэн дүрслэл болно. Тэгэхээр дээрх богд ноён Жангарыг тодотгосон нэршлийг ерөнхийлөн үзвэл 1, 3, 4, 5 дахь дүрслэл цагийн утгат хэвшсэн үг хэллэгийг зэргэд хэлбэрээр, 3, 6 - гаа нь 1, 3, 4, 5 дахь дүрслэлүүдийг сөөлжлөн холбох үүрэгтэйгээр орсон байна. Одоо бид аман яриа бичгийн хэлнээс хэрхэн ялгардаг болохыг 8, 9, 10 дахь дүрслэлүүдээс ажиглаж болно. Тухайлбал, 8 дахь дүрслэл нь орших орон байр заасан тодотгол гишүүн өгүүлбэрийг хураангуйлан орхиж бүрэн бус өгүүлбэрийн оруулбар болгон дэлгэрүүлсэн бол 9 дэх өгүүлбэрийн тавхай тавхайнаас нь гэхийн “нь” нь төлөөлөн орлосон холбоосны үргийг гүйцэтгэж дараачийн “Тансан Гомбо Найчин Лүйзэн хааны хөвүүн алд, Богд ноён Жангар” гэх шууд бус нэрлэлтийн утгат мөрүүдтэйгээ холбосон байна. Энэ 8,9,10 дахь дүрслэлийн өгүүлбэрүүд бол бүрэн бус өгүүлбэрүүд болж харин “нь” субъектийн тэмдэг нь бүрэн бус өгүүлбэрүүдийг холбох үүрэгтэй болох нь дээрхээс харагдаж байна. Үүнээс ажиглахад аман яриа нь заавал бүтэцлэгдсэн бүрэн гүйцэт өгүүлбэртэй байх ёсгүй жишээлбэл бичгийн хэлэнд “багшаа би маргааш

Монгол явж болох уу?” гэсэн асуух өгүүлбэр бол бичгийн хэлний зөв дараалалтай байна. Гэтэл аман ярианд би Монгол явж болох уу? Багшаа маргааш гэж хэлбэл маргааш Монгол явж болох уу? гэсэн санааг багш шууд л ойлгоно энэ бол чухамдаа аман ба бичгийн хэлний ялгаа юм. Үүнтэй адилхан дээрх 8, 9, 10 дугаар бүрэн бус өгүүлбэрүүд бол Жангарын удам угсааг илтгэсэн өгүүлбэр болохыг бид бүрнээ ойлгож байгаатай утга нэг юм. Үүнийг хэл шинжлэлийн үүднээс авч үзвэл: “Хүн таван мэдрэхүй хийгээд далд ухамсрын хүчинд гадаад ертөнцийг нэг талаар хурц тод, нөгөө талаар тоймлон төсөөлж тархиндаа буулгадаг. Энэ тухай Т.Гоббс “Мэдрэхүй эрхтэнд цогц буюу хэсгээр анх үүсээгүй ойлголт хүний оюун ухаанд үгүй” гэжээ. Үүнийг танин мэдрэхүүн анхдагч шат болох мэдрэхүй гэнэ (М.Базаррагчаа, 2005, х.390) гэсэн нь хүн аливаа ертөнцийн өгөгдлүүдийг тоймлон ухамсарлах хэлбэрээр мэдээллийг авдаг тиймээс харин авсан мэдлэгээ хэрэглэхдээ харилцан адилгүй байх бөгөөд эмх цэгцтэй болон эмх цэгцгүй замбараагүй дураараа хэлэхүй нь өөрөө аман ярианы эрх чөлөө бөгөөд бичгийн хэлнээс ялгарах нэгэн нотолгоо болдог байна. Ийм бичгийн хэлнээс ялгарах аман ярианы хэл зүйн онцлогийг илтгэсэн хэд хэдэн жишээг “Жангар”-ын туулийн нэршлээс ажиглаж болно.

Эрт урьд цагт гэнэ

Богд ноён Жангарай хаан гэж байжээ.

Хан дүнгэл аавтай юм байж.

Хатан дүнгэл ээжтэй юм байж... (Т.Баясгалан, 2011, х.233) гэх Жангар баатрын нэршлийн удам угсаанд хамаатуулсан тодотгол нэршлийн тодотгогч гишүүн өгүүлбэр нь тодотгуулагчийнхаа хойно нь орж өмнөх тодотгуулагчаа тодотгосон буюу өгүүлбэрүүдийн байрлал, тоочимжийн утга хамааралт өгүүлбэрийг доор нь оруулж тонгоргон хэлж хувиргасан шинжтэй. Энд гарч буй “Богд ноён Жангарай байжээ” гэсэн биед хамаатуулахын төгсгөх үйлийн нөхцөлийг дараагийн мөр дахь зэрэгцүүлэн угсрах “ж” нөхцөлөөр сүүл холбосон, ойролцоо утгат тодотгол үг давтсан, хэл зүйн хэлбэр давталтад тоочимжтой зэрэгцэх холбоогоор утга нөхцөлдүүлэн зурагласан нь аман ярианы холбох утга бүхий хэлний хэмнэлтийн зарчмыг харуулж байна. Энэ мэтчилэн “Жангар”-ын гучин гурван эх текст дэх Жангар баатрын тодотгол нэршлийн хамгийн бага мөр шүлэгт, хамгийн ихээр урвуулан хувиргасан нь 12.[Санжаа] хувилбарт бүлгийн “Үеийн үед Жангарай хаан гэж байжээ” (Т.Баясгалан, 2011, х.102) гэх өгүүлбэр болж байна. Энэ бол “ярианы хэлний зохион байгуулалт үг сонголтын хувьд бичгийн хэл шиг нарийн тогтвортой болдоггүй. Харин хэлний уян хатан ойлгомжтой чанарыг дохио, зангаа, аялга, нүд, нүүрний хувирал, хөндлөнгийн хэлний буюу

хэрэглүүр ашиглаж, илүү баяжуулж илэрхийлдэг” (Д.Хүү, 2016, х.169). Тийм учраас баатарлаг туулийн эх текст ихэвчлэн аман ярианы текст байдаг тул “байжээ”, “байж”, “гэнэ”, “гэнэ ээ”, “гэнэ дээ”, “гэлээ лөө”, “суужээ”, “өгөөрэй гэв” гэх мэт сонсогч руугаа хандсан аялга үгсээр дараачийн утга эхлэх, утга угсрах, утга төгсгөх хэлбэрээр туулиа хайлдаг байна. Эдгээр задлан шинжилж тайлбарласан жишээнүүдээсээ ажиглан үзэхэд: өгүүлбэр дэх үгсийн дэс дарааг өөрчлөх буюу гишүүдийн байрыг хөдөлгөх, өгүүлбэрийн аль бүрэлдүүлбэрийг хасах буюу тодотгогч гишүүнд өгүүлбэрийг хасах болон нэмэн дэлгэрүүлэх, баймж утгатай үг буюу чимэх үгээр хувиргах, идэвхтэй хэллэг бүтцийг идэвхгүй хэллэг бүтэц болгох, тоочимж тодотгогч өгүүлбэрийг тодотгуулагчийн хойно оруулан тонгоргох зэрэг олон хувиргах аргуудыг аман ярианд хэрэглэдэг нь жишээлбэл болгосон Жангарын тодотгол нэршлийн хэлний баримтуудаас харагдаж байна.

“Жангар”-ын Жангар баатрын тодотгол нэршилт цогцолбор дахь авиа зүйн хувиргалт

Аливаа хэлний хувиралт нь үгсийн сангийн нөөц бололцооноос гадна авиа авиалбар зүйн хувиргалтаас шалтгаалан тус үгийн дуудлага өөрчлөгддөг. Тухайлбал Т.Баясгалангийн ном дахь 33 эх текстэд Жангарыг хэрхэн тэмдэглэгдсэнийг үзвэл: <<“Жангар” [х.71, 64, 54, 106, 147, 155, 168, 171, 182, 200, 217, 253], Жангарай” [х.19, 131, 141, 195, 233, 241], “Жанрай” [х.86, 50, 45, 31, 108, 214], “Жунраа” [х.229], “Жанрвай” [х.102], “Жанхар” [х.163], “Жонхор” [х.144], “Жунгаар” [х.190]>> (Т. Баясгалан, 2011) гэж найман янзаар тэмдэглэгдсэн байх юм. Харин үүнээс хамгийн их давтамжтай нэрлэгдсэн нэршлийг үзэхэд Жангар-арван гурав, Жангарай-зургаа, Жанрай-зургаа, “Жунраа”, “Жанрвай”, “Жанхар”, “Жонхор”, “Жунгаар” тус бүр нэг нэг удаа нэрлэгдсэн байх юм. Эдгээрээс Жангар баатрын дүрийн нэршлийн хамгийн тогвортой нь “Жангар” болж, дараа нь Жангарай хэмээн ярианы хэлний өхөөрдөн дуудах дуудлагад орж, Жанрай буюу үгийн дундах “г” авиа дуудагдалгүй орхигдсоноос болж Жанарай нь “Жанрай” болжээ [магадгүй буулгагч буулгахдаа “а” авиаг орхиж тэмдэглэсэн байж болно] үүний дараачийн хувиргалт бол Жанрай нь Жунра буюу “а” авиа “у” авиагаар солигджээ. Энэ мэтээр Жангарын нэршлийн хувиралтыг ажиглан үзэхэд “ж,н,р” авианууд тод дуудагддаг учир хувиргалт явагдалгүй үлдэж “а, о, у” авианууд чанга сул дуудагдахаас шалтгаалан Жангар нь олон янзаар хувирсан болох нь харагдаж байна. Энэ авиа хувиралтыг монгол хэлний авиа зүйн ухааны, хэлний авиа “сонсгол зүйн талаас, үгүүлэхийн талаас, үүргийн талаас” гэх гурван судалбарт

харгалзуулан судалбал зохино. Ямар нэгэн дуу үүсгэгчийн тусламжаар агаарын орчин хэлбэлзэх нь физикийн талаас авиаг тайлбарлах үндэс болно. Үгүүлэхийн эрхтний хүчдэлээр үүссэн агаарын хэлбэлзэх хөдөлгөөн хүний сонсох эрхтэнд хүртэхийг сонсгол зүй үүднээс авиа гэнэ. Авианы хэлбэлзэл жигд, зохицол бүхий хэмнэлээр гарвал дуу буюу сонсголт авиа үүсэж, жигд биш, хэмнэлгүй гарвал анир буюу шуугиан үүсдэг байна.” (Ред. Ү.Ариунболд, 2004, х.49) гэснээс үзэхэд туульч ямар хоолойгоор авиаг гаргаж байгаа, ямар нутгийн аялгуутан, хэд орчим настай, хэнд хайлж байгаа, хэзээ хаана хэдэн настайдаа сонссон гэх мэт олон зүйлийн учир шалтгааны улмаас тухайн авиазүйн хувиргалт явагдах нь ойлгомжтой болж байна. Тууль хайллагыг Ч.Бауден хэлэхдээ: туулийн хамаг шинж нь сонсож байхад биш, бичлэгийг уншиж байхад илүү тод мэдэгдэх бөгөөд үлгэр туулийг үргэлжилсэн үгээр аялах, хуур хөгжимтэй шүлэглэн аялах, хөгжимгүй аялах тэргүүтэн цөм ялгаатай гэжээ”. (C.R. Bawden, 1979, х.41) Тэгвэл тууль хайллага нь хайлагч сонсогчийн харилцаан дунд үүсэн буй бүрэлдэх [тууль сурагч] нэг төрлийн ярианы хэлний хувиралтын зааг дээр бий болсон бас нэгэн хувилбарт шинэ эх үүсэж тэрхүү эхийг эзэмшсэн туульч дараа нь өөрийн гэсэн ая айзам хэмнэлээр тухайн сурсан туулиа хайлдаг байна. Энэ хайлагч сонсогчийн харилцаа нь олон хувилбарт туулийн аман эх текстийг бий болгох юм. Харин туулийг үргэлжилсэн үгээр хэлэх нь тухайн туулийн утга санаа үгийн зөв утга хадгалах ба туулийн “бичлэгийг уншиж байхад илүү тод мэдрэгдэнэ” гэдэг бол сонсогч илүү ухамсартайгаар рационалист байдлаар туулийн мэдээллийг хүлээж авах бололцоог олгож байдаг байна. Туулийг хайлж байхад нь шууд бүрэн зөв тэмдэглэж авна гэдэг бол сонсгол зүйн хувьд бараг боломжгүй зүйл. Харин үгүүлүүр зүй гэдэг нь “тухайн хэлний авиаг дуудаж хэвшсэн үгүүлэх эрхтний байрлал, үйл хөдлөлийн тогтсон хэв маягийг үгүүлүүр зүйн суурь” (Ред. Ү. Ариунболд, 2004, х.49) -ийг хэлдэг байна. Тэгвэл энд өгүүлж буй “Жангар”-ийн туульд: 1.[Лувсанжамц] “Тахил Богд хааны хүү”, 2. [Дүгэр] “Тахил Будал хааны хүү”, 4. [Пүрэвцогт] “Будан хааны ач л гэнэ” 1.[Лувсанжамц] “Бошог их хаваржаатай”, 2.[Дүгэр] “Бошгийн эхэн хаваржаатай”, “гэнэн цагаан ууланд өвөлжөөтэй”, 9.[Осор] “Гэндэн цагаан уул өвөлжөөтэй” (Т. Баясгалан, 2011, х.80) 1.[Лувсанжамц] “Жин далай, жинт далай”, 2. [Дүгэр] “Чин далай, чихэр далай” гэсэн мөр шүлгүүдийн үгүүлүүр зүйн хувьслыг ажиглан үзвэл Богдыг Будлаар, Бошог ихийг Бошгийн эхэн, гэнэнг гэндэнгээр, жинийг чинээр гэх мэт өөр өөр үгүүлүүр зүйн авиажилтыг даган хойд үгс нь даган хувирсан шинжтэй болохыг уг эхээс

ажиглаж болно. Энэ бол тухайн туульчийн хэлж хэвшсэн хэлэхүйн хэв маяг гэж хэлж болохоос энэ үг нь анхдагч, тэр үг хоёр дахь нь ч гэж үзэж болохгүй юм. Гэтэл хэлний үүргийн талаас авиаг судлан үзэхэд Жангарын удам угсааг тодотгосон өгүүлбэрт: 7.[Гончигжанцан] Даг Жамбал Зулын ач, 8.[Б.Владимирцов] Доотол Замбал хааны зулын ач, 14.[Б.Ринчен]Тахир Жамбал Зулын жич, 17. [Бадамгарав]Тавтай Дамба Зулан хааны жич, 20.[Ж.Туульс] Давцаг замбага болох Зул хааны ач дээж болох” гэх мэтчилэн Жангарыг Жамбал зулын ач, мөн жич гэж хоёр янзын утга, үүргээр илэрхийлж Зул хааны тодотгогч нь үг нь: замбага, жамбал, замбал, мөн Дамба зул хаан гэж ч гарч байна. Энэ бол “з” гийгүүлэгч авиалбар нь нөгөө “ж” гийгүүлэгч авиалбартайгаа эсрэгцсэн үгийн утга ялгаж шууд бус ч гэсэн үг бүтээврийн авианы бүрхүүлийг ялгаснаар дам утга ялгах шинжтэй болсон байна. Гэтэл авианы бүрхүүлээрээ адил үг бүтээвэр өмнөх ардах үгнээсээ шалтгаалж утга ялгасан тохиолдол бас байна. Жишээ нь:

21.[Баглай]Товхиул Бумбайн ач,
Томцог Бумбайн жич,
Үзэм Бумбайн үе,
Үеийн алдар богд ноён Жангар...
(Т.Баясгалан, 2011, х.168) гэх мөрөн дэх “Бумбайн” гэх үгийн өмнөх “Товхиул, Томцог, Үзэм” гэх гурван үг нь гурван өөр хааны нэрсийг дурдаж “Бумбайн” хойно байрлах ач, жич, үе гэх гурван үг нь эх сэдвээсээ илэрхий ялгарах бөгөөд утга самуурах явдал огт гараагүй байна.

Энэчлэн Жангар баатрын нэрийн авиалбарын хувирлыг танихуйн хэл шинжлэлийн: “мэдлэг олж авах, хадгалах, өөрчлөх, ашиглах танихуйн үйл ажиллагааны тухай олон шинжлэх ухааны цогц, явцуу утгаар-мэдлэг олж авах, хэрэглэх салбар хоорондын судалгаа (Н.Нансалмаа, С.Долгор, 2014, х.21) гэсэн тодорхойлоос үзэхэд ерөөс хүний тархи, оюун ухаан нь хүлээн авах, боловсруулах, хэрэглэх түвшний үйлийг хором бүр хийж байдаг байна. Харин тухайн туульчийн хайллагатай уялдуулан үзэхэд нэгэн ижил нэршлийг олон янзаар хэлж буй нь мэдлэг хүний тархинд буй “хэлэнд” (mental lexicon-сэтгэлгээний хэл үгийн сан (Н.Нансалмаа, С.Долгор, 2014, х.50) болон phonation-авиажилт (Ч.Зэнямбуу, М.Базаррагчаа, 2014, х.4) буухдаа ихэвчлэн танихуй уламжлалт хэлбэр болох “танин мэдэх нь мэдрэх, хүлээж авах, төсөөлөх” (Н.Нансалмаа, С. Долгор, 2014, х.25) үйл ажиллагаанд суурилдаг байна. Үүнд зориулан нэгэн жишээ татвал, Увс аймгийн Бөх мөрөн сумын дөрвөд туульч Шадравын Пунсанцогоо хэлэхдээ: бичгийн хэлнээс сурсан туульчаас сонсголоороо сурсан туульч илүү сайн тууль хайлдаг. Учир нь тууль хайлж буй хүн эхлээд ая

данг нь цээжилнэ дараа нь өөрөө л туульд гардаг дүр дүрслэлүүд нь тодрон гарч ирдэг. Гэрийн дотор тууль хайлж байхад гадаа түлээ хөрөөдөж байгаа хүн сурчихсан байдаг... гээд цааш хэлэхдээ: Хангил Ташаа хар морьтой дайн цэргийн хөвүүн” гэх туульд “уриан ганц мод нь найтаг жийтэг байхын цагт гэдэг” энд гарч буй “уриаг” би Зодов багшаас асууж байсан юм. Уриа гэдэг нь уулын оройд тогтсон цөөхөн хэдэн өндөр моддыг хэлдэг, гал бургасан нойтон, найтаг байхын цагт гэдэг нь гал түлдэг модыг хэлж байна. Модон байхгүй гал нь үгүй шүүдээ” (О.Отгонбаатар, 2016) гэсэн ярилцлагаас ажиглахад нэгдүгээрт: сонсож ухамсарлахуй нь танин мэдэх нь мэдрэхүйн чадвараараа мэдээллийг хүлээж авна. Энэ нь хувь хүний авьяасаас шалтгаалж туулийн ая айзам хэмнэл, ерөнхий утга санаа ойлгож сурдаг. Хоёрдугаарт: тухайн туулийн үгсийн сангийн өвөрмөц онцлогийг ухамсартайгаар асууж лавлан ойлгох үйл явагдана. Дөрөвдүгээрт амьдралаас олж авсан туршлагат үгсийн сан болон хэлэхүйн авиажилтын дадал зуршлаасаа шалтгаалан тухайн үгсийн санд хувиралт үүсгэдэг байна. Энэ нь чухамдаа аман ярианы хэл нь бичгийн хэлийг бодвол тогтворгүй, хөдлөнгө шинжтэй болохыг харуулж байна.

Эцэст нь тэмдэглэхэд: юуны өмнө, хэл шинжлэлийн хүрээнд хамрах сэтгэлгээний бараг бүх үйлдэл нь ухамсаргүй сэтгэхүйн түвшинд болж байдаг. Бид ярьж байхдаа хэлний үгзүйн болон өгүүлбэрзүйн хуулиудыг ухаардаггүй. Тэр ч байтугай, бид хэлж буй үгсийнхээ утгыг ялгахын тулд хэрэглэж буй авиалбаруудаа ухамсартай мэдлэгийн хүрээнд эзэмшиж байдаггүй. Авиалбар бүрийг ялгах элементүүд рүү задлах боломж олгож буй фонология [reper.phone “авиа” -“Logos сургаал”] эсрэгцлүүдийг бид бүр ч бага түвшинд ухамсарлаж (ийм бололцоо хааяа бидэнд байдаг хэмээн таамаглавал шүү дээ) байна. Эцэст нь гэхэд, бид өөрийн хэлнийхээ хэл зүйн, эсвэл авиалбар зүйн дүрмүүдийг томъёолж байхад ч интуици (увдис зөнгийн) ойлгохуй байхгүй байгаа нь мэдэгдэнэ” (Орч. Ж.Отгонбаяр, 2013, х. 54) гэх нь үнэндээ ярианы хэлэнд мэдээллийг тойм байдлаар ухамсаргүйгээр ухамсарлаж, үргэлж нэмэгдэхүүнд, хэл зүйн үгсийн сангийн гүн ухамсарт буй хөдлөнгө үгсийн (оюун ухааны боловсруулах үйл явц нь үргэлж мартагнах санагалзах үйлд суурилдаг) гинжилсэн үг, өгүүлбэрүүдийн холбоосыг ухамсарт болон ухамсаргүйн хоёрдмол (инвариант) байдлаар хэлэхүйн хэл зүйн үгсийн санд хувиралт үүсдэг байна.

Энэ ухамсарт болон ухамсаргүйн хэл зүйн үгсийн хэлэхүйн хэлбэр нь бичгийн зохиолыг бодвол аман ярианы тэр дундаа монгол туулийн

хэлэхүйгээс гарган авч шинжилж болохыг бидний дээр ишилж баримт болгон задалсан, шинжилсэн текстийн хэл зүйгээс бүрнээ харагдаж байна. Монгол туульд хэлэхүй нь ямар нэгэн хэл зүйн дүрэм, найруулгын тогтсон хэв маягт баригдалгүй дур зоргоороо ярих үйлд суурилдаг болохоос биш тухайн үг, өгүүлбэр нь өөр өөрийн үнэт зүйлсийг хадгалсаар ирснийг бид мэдэх билээ.

“Жангар”-ын Жангар баатрын тодотгол нэршилт цогцолбор дахь нийлмэл өгүүлбэрийн хувиргал

Жангар баатрын тодотгол нэршилт, дүрслэлийн хувиралтыг ажиглан үзэхэд ихэвчлэн монгол хэлний нийлмэл өгүүлбэрүүдийн нэгдсэн цогцолборт хэв шинжтэй байдаг. Тэдгээр дүрслэхүүнүүд нь олон хувилбаруудад агуулга ба хэлбэрийн хувиралтаар хураангуйлсан ба дэлгэрүүлэх сэлгэцээр хувиргалт явагдаж, залгамжилсаар өөр хоорондоо адилгүй олон бүлгүүдийг бүрэлдүүлсэн байдаг.

Монгол хэл шинжээч, судлаачид нийлмэл өгүүлбэрийн хувиралтыг: энгийн ба нийлмэл өгүүлбэрийн харьцаанд өгүүлбэрт хувиргал хийдэг аргыг ажиглахад энгийн өгүүлбэрийг нийлмэл өгүүлбэр болгодог ёс, нийлмэл өгүүлбэрийн гол ба гишүүн өгүүлбэрийн өгүүлэгдэхүүний хэлбэрт өөрчлөлт оруулдаг ёс, тэрчлэн зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийг угсарсан нийлмэл болгох, угсарсан нийлмэл өгүүлбэрийг зэрэгцсэн нийлмэл болгох, харилцан захирсан нийлмэл өгүүлбэрийг угсарсан нийлмэл өгүүлбэр болгох, нэг нийлмэл өгүүлбэрийг угсарсан нийлмэл өгүүлбэр болгох, нэг нийлмэл өгүүлбэрийг нөгөөгөөр нь дэлгэрүүлэх ёс гэх мэт өгүүлбэрүүдийн харьцаа холбоо, холбох хэрэглүүрийг солих, давтаж холбох ёс, өгүүлбэрийн мэдээллийн бүтэц ба утга санаанд нь эрс өөрчлөлт гардаг ёс нэлээд түгээмэл байдаг (Б.Пүрэв-Очир, 2006, х.99) хэмээн онол арга зүйн үндсэн чиглэлүүдийг заан тодорхойлсон байна. Энэхүү хэл, хэлэхүйн хувиралтыг Жангар баатрын тодотгол нэршилээс ажиглан үзвээс:

15[Доосүрэн] Эрт урьд цагт

Наашлагтай төрсөн

Наян живаа баатартай,

Итгэлтэй төрсөн

Ерэн живаа баатартай төрсөн

Богд Дэчин Жангарай хаан байжээ...(Т.Баясгалан, 2011, х.131) гэх дүрслэл дэх “эрт урьд цагт наашлагатай төрсөн наян живаа баатартай” гэсэн цагийн утгат, учир шалтгааныг заасан өгүүлбэр нь бие биеэ дэлгэрүүлж, баймж утгаар мэдээллийн бүтцээ тэлсээр эрт цагт төрсөн баатруудыг тодотгон нэрлэсэн хоёр нийлмэл өгүүлбэр нь нэг нэгэндээ нөлөөлж хувьссан, угсарсан, ойролцоо утгат нийлмэл өгүүлбэрүүдээр Богд Дэчин Жангар хааны тодотгол нэршил болгосон байна.

Тэгвэл 18.[Думаа] Эрт урьдын цагт Үйзэн-Алдар хааны үр,

Насан-Алдар хааны хүү,

Наран –Алдар хааны зээ

Доорд Түвшин

Догшин Богд ноён

Жангар хаан гэж байжээ... (Т.Баясгалан, 2011, х.147) гэсэн Жангарын удам угсаанд хамаатуулсан тодотгол нэршлийг ажиглан үзвээс: тоочих зэргийн утгат хэлний хэмнэлтийн зарчмаар утга шилжүүлсэн “хааны үр, хааны хүү, хааны зээ” гэх угсраа үгст, дундын “Алдар” гэсэн гишүүн өгүүлбэрээр дэлгэрүүлсэн ба дундын гишүүн өгүүлбэрийг зэрэгцсэн гол өгүүлбэрүүд утга зүйн хувьд нэгтгэн захирсан өгүүлбэрүүд нь найруулга зүйн талаасаа зэргэд маягтай бөгөөд “түвшин, догшин” гэсэн эсрэгцсэн утгат үгсээр угсарсан “Доорд түвшин догшин зэрэгцсэн богд ноён Жангар хаан” гэх нийлмэл тодотгогч тодотгуулагчийн харьцаат өгүүлбэрийг дэлгэрүүлэн тодотгосон шинжтэй байна. Үүнээс ажиглахад аман ярианы хэл нь бичгийн хэлийг бодвол дэлгэрэнгүй ба задгайрсан дур зоргын шинжтэй угсарсан, зэрэгцсэн, харилцан захирсан бүхий л шинжийг өөртөө агуулга, хэлбэрийн хувьд нэгтгэсэн нэг нь нөгөөдөө ил ба далд хэлбэрээр нөлөөлсөн өвөрмөц онцлогтой байдаг байна. Мөн утга зүйн хувьд өгүүлбэр төгсгөсөн боловч төгсгөл нь өөрөө дараачийн ижил утгын тодотгол болох, төгсгөл нь субъектийн тэмдэгтээр төгсгөсөн ба холбох үүргээр төгсгөх, утга төгсгөж утга залгамжлах ёс эвдэгдэж өөр шинэ утгыг залгах гэх нэлээд өвөрмөц онцлогуудыг дараа дараачийн хэлний баримтуудаас ажиглагдах болно. Тухайлбал:

5.[Дамбийбалжир]

Түрүү сүүлд гарсан

Тавтай Замбал хааны ач л гэнэ дээ

Тахь Будан хааны жич л гэнэ дээ

Үйзэн жанжин хааны хөвүүн

Үйзэн –Алдар хаан гэв.

Үеийн баахан байсан ноён

Богд бурхан ноён

Жанрай хаан гэж л байв уу гэнээ... (Т. Баясгалан, 2011, х.50) гэсэн эрээвэр хураавар өгүүлбэрүүдийг нэгтгэсэн ганц утга нь Жангарын удам угсааны тайлал болно. Үүний хэл зүйн хэлбэржилтийг үзэхэд: “түрүү сүүлд гарсан” гэх утга тонгорсон үгт, цагийн утгат хамаатуулсан өгүүлбэрээр тодотгуулагчийн харьцаанд орших “Тавтай Замбал хааны ач л гэнэ дээ, Тахь Будан хааны жич л гэнэ дээ” гэх харилцан зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрүүд, “үйзэн” гэх нэг утгат үгээр толгой холбон зэрэгцүүлсэн “Үйзэн жанжин хааны хөвүүн, Үйзэн-Алдар хаан гэв” гэх өгүүлбэр, “ноён”-оор сүүл холбон зэрэгцүүлсэн “Үеийн баахан байсан ноён, Богд бурхан ноён” нийлмэл

өгүүлбэрүүд нь цөм Жангарын тодотгол болж байна. Энэ бол ярианы хэлэнд өгүүлбэрзүйн байршлаас илүүтэй өгүүлбэрүүдийн цөм утга нь чухал болохыг харуулж байна. Яаж найруулан хэлэх нь онц биш харин хэвшсэн өгүүлбэрүүдийг хэрхэн толгой сүүл холбох ба үндсэн утга зүйн дэс дарааг зөв гаргах нь чухал юм. Энэ нь товчхондоо туульчдын үгсийн сан болон хэлэхүйд угаас байсан ишлэлт сэтгэлгээ гэж хэлж болно. Эдгээр эрээвэр хураавар нийлмэл өгүүлбэрүүд нь туульчийн хайлж буй хөг эгшиг, ая айзам зэргээр амь орж, утга төгөлдөр сонсогддог болов уу гэмээр юм. Харин зарим тохиолдлын үед туульч ухамсартайгаар үг өгүүлбэрзүйн утга залгамж холбоог зөв гаргасан хайллага байдаг. Энэ нь ихэвчлэн хүүрнэн хэлсэн туульд тохиолддог зүйлс болно. Тухайлбал, Б.Я.Владимирцов Баядын нэгэн лам Төвд орох замдаа Халхын Сайн ноён хан аймгийн (одоогийн ар хангай) нутагт 1761 онд шилжсэн суурьшсан халхажсан өөлд нараас тогтоон цээжилсэн бөгөөд үүнээс хэдэн жилийн дараа надад өгүүлэн ярьсан юм” гэж тэмдэглэсэн Жангарын нэгэн бүлэг болон Говь-Алтай аймгийн Шарга сумын “Гэцээн” Санжаагаас 1966 онд хэл зохиолын хүрээлэнгийн шинжилгээний ангийнхан тэмдэглэжээ. Санжаа уг Жангарыг өгүүлэн хэлдэг гэх хоёр туулийн Жангар баатрын тодотгол нэршлийг дор сийрүүлбэл:

8.[Б.Я.Владимирцов.т]

Үеийн үед

Оршин суугч

Богд ноён Жангар хаан гэж

Нэгэн хаан байв гэнээ... (Т.Баясгалан, 2011, х.106) гэж “үеийн үед оршин суугч” цаг хугацаа орших, орон байр заасан зэрэгцэх холбоотой хоршоо үгээр, үйлийн нөхцөлдүүлэн холбохын “ж”-гээр ойролцоо утга давтсан “Богд ноён Жангар хаан гэж нэгэн хаан байв гэнээ” гэсэн нийлмэл өгүүлбэртэй холбосон байна. Харин хамгийн товчоор.

12.[Санжаа]Үеийн үед

Богд ноён Жанрай хаан ... (Т.Баясгалан, 2011, х.233) гэсэн Т.Баясгалангийн “Жангар” номд “Богд ноён Жанрай хаан” гэх нэрт Жангарын нэгэн бүлгийг Завхан аймгийн Их Уул сумын Зарт баригадын харьяат Долгорын Дамбийбалжираас 1976 онд хальсанд бичиж авчээ. Жангарын энэ бүлгийг ажиглахад эхлээд мөр толгой холбосон маягаар буюу хайллага хэлбэртээ хэлж байгаад дунд хэсгээсээ үлгэрлэн хүүрнэн өгүүлэх маягаар хэлсэн байна. Дамбийбалжир уг “Жангар”-ыг жангарын үлгэр гэжээ. Үүнээс ажиглахад туульч Жангарыг үлгэрлэн хэлэх болон аялгуулан хайлах хоёр хоорондоо ялгаатай байна. Энэ маягийн ялгааг Б.Цогжин “хоёр тууль бүхий шугамын нэг тууль нь бичгийн зохиол, нөгөө тууль нь бичиг үсэг мэдэхгүй ардын авьяастны аман бүтээл

байна гэхэд үүний дунд юу орших бэ? Тэгвэл энэ зайд аль алиных нь буюу аман ба бичгийн зохиолын дундын чанартай үзэгдлүүд оршино... (Б. Цогжин, 2010, х.152)” гэжээ. Тэгвэл туулийн аман хайллагаас алслагдах процесс явагдаж буй, үлгэрлэн хүүрнэн өгүүлэх явцад тухайн текстийн утга агуулга, хэл зүй нь бичгийн хэл болон ярианы хэлний завсрын шинжтэй болж үсэг бичгийн шинжтэй тэмдэглэл рүү чиглэсэн ба аялгуулан хөгжимтэй хайллагыг бодвол текстийн хувьд хураангуй тойм ерөнхий утга санааг гаргасан шинжтэй болдог байна. Тиймээс эх зохиолын эрэл гарлыг судлаачид тэмдэглэх үед, тухайн туульч туулиа аялгуулан хайлсан, хүүрнэн өгүүлсэн гэх мэт мэдээ мэдээллийг тодорхой дурдаж өгөх нь аман ба бичгийн хэлний зүйн харьцуулсан судлалд бас нэгэн чухам баримтын тулгуурыг бэлтгэсэн хэрэг болох юм. Аман туулийн ярианы хэлэнд Монгол яруу найргуудын түгээмэл шинж болох найруулгын эхэн, сүүл ижилсэх ур маяг, зэрэгцэн холбох, бүхэл эхээрээ найруулгын зэрэгцүүлэл маягаар зохиогдсон нэг бадаг шүлгүүд нь эхийн өгүүлбэрүүдийн холбоо үүсгэх нэгэн хэрэглүүр болдог онцлогтой. Тухайлбал:

24.[Б.Ринчен.тэмд]

Алтай хангайн

Арван гурван

Ахил уулын

Энгэрээр нутагланхан суудаг

Үйзэн Замбал хаан,

Үйзэн Замбал хааны хүү

Үетэй Замбал хаан,

Үетэй Замбал хааны хүү

Үрийн ганц Богд Жунгаар ноён хүү гэж байжээ... (Т. Баясгалан, 2011, х.190) гэж толгой сүүл холбосон нийлмэл өгүүлбэрүүдийг гинжлэн зэрэгцүүлсэн холбоогоор зурагласан бол...

4.[Батцогт]

Тахил Будан хааны ач л гэнэ

Тавдай Замбал Зулын жич л гэнэ

Үйзэн-Алдар хааны хүү л гэнэ

Үеийн баахан

Богд ноён Жанрай хаан гэж байжээ... (Т.Баясгалан, 2011, х.45) хэмээх нь үг зүйн талаасаа салангид, туслах бүтээврийн үүрэгтэй онцолборыг илрүүлэх “л”-ээр “ач, жич” гэх үгсийг чухалчилсан сүүл холбосон зэргэд маягийн тодотгол гишүүнт нэрийн бүлэг дэлгэрсэн хоёр бүрэлдэхүүнт цогцолбор нь утгын хувьд зүйчилсэн шинжтэй байна. Харин “баахан” гэдэг бол багахан гэсэн үгний хувилбар бололтой. Мөн энд гарч буй Жангарын баатрын нэршилд байнга давтагдах “ач, жич” үгсийг Б.Пүрэв-Очир: дэслэх дугаарлах утгыг заадаг, хоёрт, эцгээс дооших, хүүхдийн эш удмыг заах утгатай, иймээс нэршүүлэх утга үүрэг бүхий нөгөө “ч” дагавар нь а-, хо-, жи-,

гу-, дө, та,... язгууртай наалдаж, ач, жич, хоч, гуч, дөч, тач гэх мэт хэлбэрүүд үүсжээ” гэсэн утга зүйн тайллаас харвал “ач, жич” нь цөм утгын шинжээрээ дэслэх дугаарлах утгатай, хэлний цуваа цагийн үүднээс нэр үгийн утгаар хэрэглэсэн байна. Энэ мэт Жангар баатрын тодотгол нэршилт цогцолбор өгүүлбэрүүдийн бүтэц бүрэлдэхүүнийг хураангуйлан үзвээс монгол аман туулийн хэл яриа үүсэх зарчим [language production language generation] нь нэгэн ижил туурвих хэлбэрийн бүтэц ноёрхох бөгөөд тэдгээр нь хэл хэлэхүйн талаасаа цөм өгүүлбэрийг дэлгэрүүлэх арга, хураах буюу урвуулан хувиргах ёс, давтах ёс болон давталтаар хувиргах арга, өгүүлбэрийн аль нэг бүрэлдүүлбэрийг хасах, харилцан захирсан, зэрэгцсэн, угсарсан, нийлмэл өгүүлбэрийн хувиргал гэх мэт Монгол хэлний олон хувиргалт хэл, хэлэхүйн харьцаанд оршиж байна.

Дүгнэлт

Жангарын тууль дахь Жангар баатрын тодотгол нэршилт цогцолборын хэл, хэлэхүйн зарчмыг ерөнхийлөн дүгнэвэл дараах хэд хэдэн бичгийн зохиолоос ялгарах шинжит онцлогтой байна.

- Туульч анхлан туулийг сурахдаа тухайн туулийнхаа ерөнхий утгыг мэдрэмж зөн билэг, мэдрэхүйн эрхтнээрээ тоймлон сурдаг. Энэ нь хожмын тууль хайллагын үгсийн санд хувиралт үүсэх шалтгаан болдог. Мөн туульч багшаасаа зарим нэг үгсийн утга агуулгыг лавлан тогтоодог нь тогтворт үгсийн санг бүрэлдүүлдэг байна.
- Туульч сурсан туулиа өөрийн оюун ухаанд боловсруулан тархины текст дэх удамшлын үгсийн сангаараа нэгтгэн хураангуйлах буюу нэмэн дэлгэрүүлэх хувиралтыг үүсгэдэг байна.
- Туульчийн хэл, хэлэхүйн эрхтний байршил, нутгийн аялгуу, хэлж хэвшсэн үгсийн аялга зэргээс үгсийн сангийн хувирал үүсдэг.
- Аман текстээс бичгийн текстэд буулгах үед сонсогч буюу буулгагч буруу буулгаснаас амаас уламжилсан бичгийн текстэд хувиралт үүсдэг. Хайлагч сонсогч руугаа хандсан харилцаа үүсгэсэн аялга үгсийг цогцолборуудын төгсгөлд хэлж өгдөг байна.
- Зарим тохиолдолд туульчийн мартагнах, санах үйл явц нь аман ярианы үгсийн сангийн эмх цэгцгүй тогтолцоог үүсгэж, өгүүлбэрүүд нь тогтсон нэг байршилт баригдалгүй үг нэмэх, хасах, утга шилжүүлэх үг зүй авиа зүйн хувирлыг чадамгай ашигладаг ба эмх цэгцгүй хэлэхүйн дутууг хөг, ая айзам нөхвөрлөдөг.
- Туулийн нэр үг нь тодруулбал Жангар баатрын нэр нь хувирах боловч үгийн язгуур шинжээ огт алдаагүй байна. Энэ үг нь утга зүйн лавлагаатай холбоотой билээ.
- Тууль хайллага нь хайлагч сонсогчийн

харилцаан дунд үүсэн буй бүрэлдэх [тууль сурагч] нэг төрлийн ярианы хэлний хувиралтын зааг дээр бий болсон бас нэгэн хувилбарт шинэ эх үүсэх боломжийг бий болгодог байна.

- Тууль нь ихэвчлэн монгол шүлгийн найруулга болох толгой, сүүл холбоцод суурилдаг.
- Туулийн аман хайллагаас алслагдах процесс явагдаж буй, үлгэрлэн хүүрнэн өгүүлэх явцад тухайн текстийн утга агуулга, хэл зүй нь бичгийн хэл болон ярианы хэлний завсрын шинжтэй болж үсэг бичгийн шинжтэй тэмдэглэл рүү чиглэсэн ба аялгуулан хөгжимтэй хайллагыг бодвол текстийн хувьд хураангуй тойм ерөнхий утга санааг гаргасан шинжтэй болдог байна.
- Монгол туульд хэлэхүй нь ямар нэгэн хэл зүйн дүрэм, найруулгын тогтсон хэв маягт баригдалгүй дур зоргоороо ярих үйлд суурилдаг болно.

Ашигласан материал

- Ариунболд, Ү. (Ред). (2004). Монгол Улсын боловсролын их сургууль. Монгол судлалын сургууль. Монгол хэл шинжлэлийн тэнхим, Орчин цагийн монгол хэл., Улаанбаатар
- Базаррагчаа, М. (1989). *Монгол хэлний эхийн тухай*, 12. Улаанбаатар
- Баясгалан, Т. (2011). “Жангар” <<МУ-ын нутаг дэвсгэрээс тэмдэглэж авсан “Жангар”-ын бүлгүүд>>, Улаанбаатар
- Базаррагчаа, М. (2005). Монгол хэлний өгүүлбэр судлал. Улаанбаатар
- Зээнямбуу, Ч., Базаррагчаа, М. (2014). Хэл шинжлэлийн нэр томъёоны тайлбар толь. Улаанбаатар
- Нансалмаа, Н., Долгор, С. (2014). Танихуйн хэл шинжлэл. Улаанбаатар
- Отгонбаяр, Ж. (2013). Лэви Строс. Орч. Бүтцийн антропологи. Улаанбаатар
- Отгонбаатар, О. (2016 оны 7 сарын 29 нд. 1 цаг 35 минут). “МУ-ын Увс аймгийн Бөх мөрөн сумын дөрвөд ястан Шадравын Пунсанцогоо гэх туульчтай хийсэн сурвалжлага”-аас буулгав. Улаанбаатар
- Пүрэв-Очир, Б. (2006). Монгол хэлний энгийн ба нийлмэл өгүүлбэрийн хувиргал. Улаанбаатар
- Пүрэв-Очир, Б. (2007). Монгол хэлний бүтэц үүрэг хэрэглээ. Улаанбаатар
- Пүрэв-Очир, Б. (2009). Үг, өгүүлбэрийн амьдрал араншин, эрчим энерги, соёл хэрэглээ. Улаанбаатар
- Хүү, Д. (2016). *Монгол хэл яриа*. Улаанбаатар
- Цогжин, Б. (2010). Монгол аман туулийн шүлэг зүй. Улаанбаатар
- Mauss, M. (1950). Sociologie et anthropologi,
- Bawden, C. R. (1979). Remarks on Some Contemporary Performances of epics in the MPR-Die mongolischen Epen, 41.